



НИЙСЛЭЛИЙН СОНГИНОХАЙРХАН ДҮҮРГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ

2021 оны 3 сарын 10 өдөр

Дугаар 4/29

Улаанбаатар хот

Ёс зүйн зөвлөлийн бүрэлдэхүүнд  
өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, Засгийн газрын 2019 оны 33 дугаар тогтоол, Засаг даргын Тамгын газрын албан хаагчдын 2021 оны 03 дугаар сарын 05-ны өдрийн Ёс зүйн зөвлөлийн гишүүдийг өөрчлөх хурлын 01 тоот тэмдэглэл, хороодын албан хаагчдын 2021 оны 03 дугаар сарын 09-ний өдрийн Ёс зүйн зөвлөлийн гишүүдийг өөрчлөх хурлын 01 тоот тэмдэглэлийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Дүүргийн Ёс зүйн зөвлөлийн гишүүн Б.Мөнгөншагай, Р.Ганбаяр нар нь өөр ажилд шилжин ажиллах болсон, Б.Даваабаяр нь хүүхэд асрах чөлөөтэй тул ёс зүйн зөвлөлийг дараах бүрэлдэхүүнтэйгээр 3 жилийн хугацаатайгаар шинэчлэн байгуулсугай.

Ёс зүйн зөвлөлийн дарга:	А.Батсайхан	Төлөвлөлт, гүйцэтгэлийн хяналт, шинжилгээний хэлтсийн дарга
Гишүүд	Д.Амарбаясгалан	Хууль, эрх зүйн хэлтсийн дарга
	С.Алдармаа	38 дугаар хорооны зохион байгуулагч
	М.Оюунцэцэг	Аж ахуйн тасгийн тохижилт, үйлчилгээ хариуцсан ажилтан
Нарийн бичгийн дарга:	Ш.Насанбуян	Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн нэг цэгийн үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн

2. Төрийн албан хаагчийн ёс зүйн дүрмийн хэрэгжилтийг зохион байгуулах ажлын төлөвлөгөөг боловсруулан ажиллаж, төлөвлөгөөний биелэлтийг хагас, бүтэн жилээр тайлагнаж ажиллахыг ёс зүйн зөвлөл /А.Батсайхан/-д үүрэг болгосугай.

ДАРГА



Д.ТӨМӨРБААТАР

1180210334